

Хичээл №8

Үндэсний уламжлалт хувцас ирээдүйд хэрхэн ашиглагдах бол? (Асуудал дэвшүүлсэн хэлэлцүүлэг)

Discussion topic: **“How to use in future the traditional clothings of nations”**

Бид энэ сэдвээр одоо байхгүй, ирээдүйд бий болох зүйлийг урьдчилан хэлэлцэх гэж байгаа учраас өмнөхөөс ч илүү нарийн судалж, бодож боловсруулах хэрэгтэй болж байна. Үүнд бидний өмнөх хичээлүүдээр ажилласан утгын сүлжээнүүдийн утгын тайлал хэрэгтэй болно. Иймээс та бүхэн өмнөх хичээлүүдээр хийсэн ажлуудаа дахин эргэн харж, дахин бодож боловсруулан хэлэлцүүлэгт бэлдээрэй.

Энэ хичээлээр би та бүхэнд санаа өгөх зорилгоор, утгын сүлжгээр дамжуулан хэлэлцэх асуудал боловсруулсан байгаа. Та бүхэн баг багаараа саналаа боловсруулах хэрэгтэй. Багийн гарагж байгаа санал бол нэг хүний саналыг бодвол бүр ч илүү чухал байх болно.

Цаашдаа баг бүр энэ сэдвийн хүрээнд семинарын хичээлд зориулж асуудал дэвшүүлж хэлэлцүүлэнэ. Санал гаргаж байгаа баг гаргасан саналаа өөрсдөө удирдаж хэлэлцүүлэл хэлэлцүүлэг маань бүр ч илүү сонирхолтой, үр дүнтэй байх болно.

Хэлэлцүүлэгт дэвшүүлэх миний санал:

- 1- рт, ирээдүйн нийгмийн тухай төсөөлөл, ялангуяа ирээдүйн нийгмийн үзэл санаа, үнэт зүйл юу байх вэ? гэдгийг голлон анхаарах,
- 2- рт, ирээдүйн хүмүүс ямархуу хүсэл мөрөөдөлтэй, дүр төрхтэй байх бол?
- 3- рт, түүнд хувцас ямар үүрэгтэй байх вэ? гэсэн багц асуудлуудыг тойрч хэлэлцүүлэх саналтай байна.

Үүний тулд, дараах утгын сүлжээг өгч байна.

Энэ утгын сүлжээг боловсруулахдаа хувцасны хэлбэр загварын гадна талдаа илрэх шинж чанарт бус харин дотоодод нь агуулагдаж буй мөн чанарт илүү ач холбогдол өгсөн байгаа.

Миний судалж, ойлгосноор бол, бидний хүрч буй ирээдүйн амьдралын утга учир бол “Хүн бүрийн аз жаргал”- аар хэмжигдэх явдал юм байна гэж ойлгож байгаа. Яагаад гэвэл,


Өнгөрсөн зуунд хүн төрөлхтөн маш олон дэвшилтэт ололт амжилтуудаар дүүрэн байж, дэлхийн улс орнууд нэг хүнд ноогдох ДНБ-ний өсөлтөөр уралдаж байсан, өөрөөр хэлбэл тухайн улсын хөгжлийн төвшинг 1 хүнд ноогдох ДНБ-ний хэмжээгээр хардаг буюу эдийн засгийн өсөлтөөр нь тухайн улсыг хөгжиж байна гэж үздэг байлаа. Энэ нь эцэстээ материаллаг үйлдвэрлэлийг хэт өсгөж, байгаль дэлхийгээ сүйрэлд хүргэж байгаагаа ойлгосон. Ялангуяа хувцас загварын салбар энэ тал дээр дээгүүр ордог тухай бид 7-р хичээлээр тодорхой жишээ баримттай ярилцсан байгаа. (Эндээс бид бас нэг зүйлийг анхаарах хэрэгтэй. Энэ нь юу вэ, гэвэл бид өнгөрсөн түүхээ судалснаар, өнгөрсөнд гаргасан алдаагаа дахин давтахгүй байхаар ирээдүйгээ төлөвлөхөд ашиглах явдал юм.)


Одоо харин байдал өөрөөр эргэж байна. Бидний хөгжил дэвшил гэж ойгож байсан зүйлийн мөн чанар нь танигдаж, ДНБ, эдийн засгийн өсөлт зэрэг нь улс орны хөгжлийн

гол үзүүлэлт байхаа нэгэнт больсон. Харин, иргэдийн аз жаргалын төвшингөөр тухайн улсын хөгжлийг хэмжих эхлээд байна.

Үүнтэй холбогдуулж 4-р хичээлээр судалсан Бутан улсын тухай эргэн санъя. Бутаны засгийн газар нь хүн амын сэтгэл хангалуун байдал нь улсын хөгжилтэй чухал холбоотой хэмээн үзээд, иргэн бүрийнхээ оюун санааны дотоод ертөнцөд анхаарал тавихын тулд 2008 онд "Нийтийн аз жаргалын комисс" байгуулж ажиллаж байгаа нь үнэхээр ирээдүйтэй алхам байсан байна. Бутанчууд эртний Грекийн философич Эпикурын зарчмтай адил зарчмыг баримталдаг байж магадгүй гэж санагдаж байна. Гэхдээ тэс өөр ялгаа бас тэдний дунд байдаг. Эпикур бурхан шүтээн, хойд насны эсрэг үзэлтэй, гэхдээ амьдралын цорын ганц зорилго бол "Аз жаргал" гэж үздэг. Харин Бутанчууд бол бурхан шүтдэг, хойд нас байдагт итгэдэг, мөн бүх нийтийн аз жаргалыг хамгийн эрхэмд тооцдог. Үүний нэгэн адил үндэстэн бүхэн, хүн бүхэн аз жаргалыг хүсдэг. Хүн бүхний туйлын энэ хүслийг өнөөг хүртэл өөр зүйлээр буюу материаллаг зүйлээр орлуулж, андуурч иржээ. Тэгвэл ирээдүй үүнийг жинхэнэ утгаар нь эрхэмлэж эхлээд байна. Иймээс, ирээдүйн хүмүүст аз жаргалыг мэдрүүлэх хувцас ямар байх ёстой вэ? гэсэн эрэл хайгуул хийлгэх зорилгоор энэ удаагийн утгын сүлжээг боловсруулав.

Утгын сүлжээ- 14





Аз жаргалыг мэдрүүлэх хувцас нь байгальд болон хүний бие организмд хоргүй материалаар хийгдсэн, биед эвтэй, хөнгөн авсаар, олон янзаар хувирган хэрэглэх боломжтой, хүмүүсийн эрүү мэнд, биеийн өөрчлөлтийг хянаж мэдээлдэг байх, цаг агаарын байдалтай зохицон хүний биеийг хамгаалдаг байх зэрэг олон шаардлагыг нэгэн зэрэг хангахаар шийдэгдсэн хувцас шаардлагатай гэж төсөөлөгдөж байна.

Одоогийн байдлаар материалын хувьд шинэ технологээр шийдсэн, биед эвтэй, хэлбэр загварын хувьд насны онцлог, үндэсний хэв маягт тохируулан хэрэглэж болох шийдэлтэй, төрөл бүрийн нэмэлт төхөөрөмжүүд байрлуулах, хамтруулан шийдэх бололцоотой загваруудад Иссей Мияакигийн загварууд орно гэж үзэж байгаа учраас утгын сүлжээнд түүний загваруудыг голчлон оруулсан байгаа. Мөн СУИС-ийн ДДУС-ийн 2020 оны төгсөгч Т.Солонгын “Nuno felting” техник ашиглаж зохион бүтээсэн загварыг Иссей Мияакигийн техник, орчин үед туршигдаад байгаа дэвшилтэт технологүүд, мөн уламжлалт монгол хувцасны загвартай хослуулж цаашид улам хөгжүүлэх боломжтой гэж үзэж оруулсан тул та бүхэн эдгээрийг судлан, бүтээлч ажил болгох тал дээр анхааран санал боловсруулан хэлэлцүүлж, бодит бүтээлч төсөл болгож болох юм.

ДҮГНЭЛТ

Бид ирээдүйн талаар тогтмол судалж байх, ирээдүйн төлөө төлөвлөх, дэвшилтэт шинэ технологийн боломжийн талаархи мэдлэгтэй байж, ба өөрсдөө шинэ арга технологи бодож боловсруулах, үүний дээр хүний бие организмын бүтэц тогтолцоо, үйл ажиллагааны тухай судалдаг, мэддэг байх, шинэ органик материалын тухай гээд олон талын суурь мэдлэгтэй байх, дээр нь мэдээллийг боловсрууж, шийдвэр болгон хувиргах чадвар гэх мэт, энэ бүхэн зохион бүтээх ажлын чухал хэсэг байх учраас ирээдүйн дизайнерууд үүнд анхаарах хэрэгтэй болж байгаа нь судлах тусам улам бүр тодорхой болж байна.

Технологийн дэвшил нь бүтээлч байдлыг улам идэвхжүүлж, уран бүтээлчид бусад салбарийн ололт амжилтыг сонирхон судлах, мөн өөрийн бүтээсэн зүйлийг хуваалцах боломжийг олгож байгаа, бас маш олон гарц, платформууд байгааг энэ хичээлийн туршид, утгын сүлжээнүүдийг боловсруулах явцдаа ойлгож мэдлээ, та бүхэн ч бас их зүйлийг ойлгож мэдсэн гэж найдаж байна.